



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Зулзагын гол хүүхдийн зуслан 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/47/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
----------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗУЛЗАГЫН ГОЛ
ХҮҮХДИЙН ЗУСЛАН А.АМГАЛАН ТАНАА

2025.02.25 № 82

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Зулзагын гол Хүүхдийн зуслангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны А/17 тоот тушаалаар 88,774.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын данснаас шилжүүлэн бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус газар нь 2024 оны 06 дугаар сард төвийн бүсийн хүүхдийг Зулзагын Гол хүүхдийн зусланд зохион байгуулсан. Мөн 2024 онд анх удаа хүүхдүүдийг онлайн бүртгэлээр бүртгэж, төлбөр тооцоог цахимаар бүртгэсэн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Зулзагын гол Хүүхдийн зуслан нь Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ХГБХХГ-тай байгуулсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болох 4 зорилт 37 арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ 96.45 хувиар, Дархан-Уул аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ 93,5 хувиар тус тус үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/Төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	291,049,126.26	228,499,891.26
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
33	АВЛАГА	-	-
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	291,049,126.26	228,499,891.26
351	Түүхий эд материал	10,000.00	10,000.00
3511	Тусгай зориулалттай материал	-	-
3513	Эм боох материал	10,000.00	10,000.00
354	Хангамжийн материал	291,039,126.26	228,489,891.26
35410	Бичиг хэргийн материал	4,274,999.96	5,124,999.96
35420	Аж ахуйн материал	128,002,421.00	111,150,421.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	-	-
3545	Барилгын засварын материал	12,002,000.00	385,000.00
3546	Хүнсний материал	-	-
35470	Бусад хангамжийн материал	146,759,705.30	111,829,470.30
36	НӨӨЦ БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	879,893,488.16	1,051,595,925.20
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	879,893,488.16	1,051,595,925.20
392	Биет хөрөнгө	584,743,488.16	755,439,883.87
39201	Барилга, байгууламж орон сууц	452,828,660.00	452,828,660.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(20,102,424.93)	(33,131,691.45)
39203	Авто тээврийн хэрэгсэл	-	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	24,570,133.00	87,939,967.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,650,449.96)	(11,628,299.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,780,016.00	152,360,176.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,000,000.08)	(45,520,060.85)
39214	Бусад үндсэн хөрөнгө	145,785,692.00	202,135,692.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(24,468,137.87)	(49,544,559.33)
39217	Ном	-	-
393	Биет бус хөрөнгө	295,150,000.00	296,156,041.33
39301	Программ хангамж	1,124,300.00	1,079,328.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300.00)	(73,286.67)
39303	Бусад биет бус хөрөнгө	295,150,000.00	295,150,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,170,942,614.42	1,280,095,816.46
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,170,942,614.42	1,280,095,816.46


51	Засгийн газрын хувь оролцоо	1,170,942,614.42	1,280,095,816.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	295,150,000.00	295,150,000.00
51101	Өмч: - төрийн	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	875,792,614.42	984,945,816.46
51210	Өмнөх үеийн үр дүн	875,792,614.42	875,792,614.42
51220	Тайлант үеийн үр дүн	-	109,153,202.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,170,942,614.42	1,280,095,816.46



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	719,593,679.00	829,338,298.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	616,593,679.00	722,338,298.28
120	Нийтлэг татварын бус орлого	616,593,679.00	722,338,298.28
	Төсөвт байгууллага өөрийн орлого	357,916,034.00	489,174,217.28
	Үндсэн үйл ажиллагаанаас санхүүжих	310,617,440.00	50,504,000.00
	Туслах үйл ажиллагаанаас санхүүжих	43,280,000.00	438,670,217.28
	үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,018,594.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	107,131,810.00	216,900,166.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	151,545,835.00	16,263,915.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	0.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	103,000,000.00	107,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	103,000,000.00	107,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	442,340,807.72	718,525,316.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	442,340,807.72	718,525,316.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	442,054,825.53	717,115,120.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00
210101	Үндсэн цалин	0.00	0.00
210102	Нэмэгдэл	0.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	0.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
210301	Гэрэл, цахилгаан		-
210302	Түлш, халаалт		-
210303	Цэвэр, бохир ус		-



210304	байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	754,200.00	0.00
210401	Бичиг хэрэг	0.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	754,200.00	
2105	Нормативт зардал	0.00	0.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	0.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	258,362,161.77	500,703,661.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	258,362,161.77	500,703,661.06
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	0.00
210805	тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	0.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	0.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	182,938,463.76	216,411,459.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	133,411,956.04	151,859,010.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,526,507.72	64,552,448.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	285,982.19	1,410,195.48
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	285,982.19	1,410,195.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	285,982.19	1,410,195.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	277,252,871.28	110,812,982.04
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	1,659,780.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	1,659,780.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	0.00	1,659,780.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	277,252,871.28	109,153,202.04



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	456,897,440.00	596,174,217.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	353,897,440.00	489,174,217.28
120	Нийтлэг татварын бус орлого	353,897,440.00	489,174,217.28
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	310,617,440.00	50,504,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,280,000.00	438,670,217.28
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	103,000,000.00	107,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	103,000,000.00	107,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	103,000,000.00	107,000,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	456,137,440.00	575,149,717.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	456,137,440.00	575,149,717.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	455,851,457.81	573,739,521.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал		-
210101	Үндсэн цалин	0.00	0.00
210102	Нэмэгдэл	0.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	0.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс		-
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл		-
210201	Тэтгэврийн даатгалын	0.00	0.00
210202	Тэтгэмжийн даатгалын	0.00	0.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	0.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	0.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгалын	0.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		-
2104	Хангамж, бараа материал		-
210401	Бичиг хэргийн зардал		-
210402	Тээвэр шатахуун		-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	0.00
210404	Ном, хэвлэл		-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		-




2105	Нормативт зардал	0.00	0.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		-
2106	Эд хогшил урсгал засвар	-	-
210601	Багаж техник хэрэгсэл	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	-	-
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоодын томилолт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	310,435,791.77	416,709,961.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	310,435,791.77	416,709,961.06
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	-
210805	тээврийн хэрэгслийн оношилгоо	-	-
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	145,415,666.04	157,029,560.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	145,415,666.04	157,029,560.74
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	285,982.19	1,410,195.48
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт , шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	285,982.19	1,410,195.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	285,982.19	1,410,195.48
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	760,000.00	21,024,500.00
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	760,000.00	21,024,500.00
	Дотоод эх үүсвэр		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	760,000.00	21,024,500.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(760,000.00)	(21,024,500.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	139,624,000.00	-	598,539,743.14	-	738,163,743.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	139,624,000.00	-	598,539,743.14	-	738,163,743.14
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	155,526,000.00				155,526,000.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			277,252,871.28		277,252,871.28
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	295,150,000.00	-	875,792,614.42	-	859,890,614.42
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	295,150,000.00	-	875,792,614.42	-	1,170,942,614.42
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			109,153,202.04		109,153,202.04
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	295,150,000.00	-	984,945,816.46	-	1,280,095,816.46



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/төгрөгөөр/	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	599,819,200.00	594,764,021.80	(5,055,178.20)	99.2%
21	Урсгал зардлын дүн	599,819,200.00	573,739,521.80	(26,079,678.20)	95.7%
210	Бараа үйлчилгээний зардал	599,819,200.00	573,739,521.80	(26,079,678.20)	95.7%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	438,670,200.00	416,709,961.06	(21,960,238.94)	95.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	438,670,200.00	416,709,961.06	(21,960,238.94)	95.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,149,000.00	157,029,560.74	(4,119,439.26)	97.4%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	161,149,000.00	157,029,560.74	(4,119,439.26)	97.4%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	-	-
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	21,024,500.00	21,024,500.00	
	Дотоод эх үүсвэрээр		21,024,500.00	21,024,500.00	
	Тоног төхөөрөмж		15,024,500.00	15,024,500.00	
	Бусад хөрөнгө		6,000,000.00	6,000,000.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	599,819,200.00	596,174,217.28	(3,644,982.72)	99.4%
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	492,819,200.00	489,174,217.28	(3,644,982.72)	99.3%
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	54,149,000.00	50,504,000.00	(3,645,000.00)	93.3%
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	438,670,200.00	438,670,217.28	17.28	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	107,000,000.00	107,000,000.00	-	100%
132001	Орон нутгийн төсвөөс	107,000,000.00	107,000,000.00	-	100%
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-		
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
	АЖИЛЛАГСДЫН ТОО	8.00	8.00	-	100.00
	Удирдах ажилтан		-	-	100.00
	Гүйцэтгэх ажилтан		-	-	100.00
	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.00



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжиж, эрх хамгааллыг бэхжүүлэн, хүүхэд тэдний гэр бүлд чиглэсэн төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд төр, төрийн бус байгууллагын түншлэлийг сайжруулж, иргэд олон нийтэд шуурхай үйлчилгээ үзүүлнэ. Зорилго: гэр бүлийн хөгжил, тогтвортой байдлыг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах болон хүүхдийн эрхийн хөгжил, хамгааллын үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг хангах, залуучуудын хөгжил, нийгмийн оролцоог дэмжихэд оршино.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Зардлын норматив шинэчлэн батлах тухай” 2021 оны А/188 дугаар тушаал, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зулзагын гол хүүхдийн зуслангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна. Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ийн журам”-ыг үндэслэн 2025 оноос Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж мөрдөж ажиллана.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Зулзагын гол Хүүхдийн зуслан нь 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 109,153.2 мянган төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	291,049.1	228,499.9	(62,549.2)
Үндсэн хөрөнгө	879,893.5	1,051,595.9	171,702.4
Нийт хөрөнгө	1,170,942.6	1,280,095.8	109,153.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,170,942.6	1,280,095.8	109,153.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,170,942.6	1,280,095.8	109,153.2

Бараа материалын дансны үлдэгдэл 228,499.9 мянган төгрөг болж 62,549.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 271,973.8 мянган төгрөг, үнэ төлбөргүйгээр 16,263.9 мянган төгрөг буюу нийт 288,237.7 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, бараа материалын дансанд бүртгэлтэй 88,774.0 мянган төгрөгийн хөрөнгийг ОНӨГ-ын 2024 оны А/17 тоот тушаалаар үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж, үйл ажиллагаанд 262,012.9 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулж, 111,829.4 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 385.0 мянган төгрөгийн барилгын засварын материал, 111,150.4 мянган төгрөгийн аж ахуйн материал, 5,124.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал зэрэг үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,051,595.9 мянган төгрөг болж 171,702.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 13,364.5 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 7,650.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил авч, бараа материалын дансанд бүртгэлтэй 88,774.0 мянган төгрөгийн хөрөнгийг ОНӨГ-ын 2024 оны А/17 тоот тушаалаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, ДУА-ийн ИТХ-ын 2024 оны 13 тогтоолоор тоног төхөөрөмж 61,320.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ДУА-н Засаг даргын 2024 оны 01-А/491 тоот захирамжаар 8,340.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч машин, 19,200.0 мянган төгрөгийн тамирчидын байрны модон ор, 14,798.2 мянган төгрөгийн гал тогооны тавилга эд хогшил, ДУА-ийн ИТХ-ын 2024 оны 28 тогтоолоор 159 ширхэг 23,850.0 мянган төгрөгийн хашаа, ОНӨГ-ын даргын А/20 тушаалаар 110 ширхэг 16,500.0 мянган төгрөгийн хашааг үнэ төлбөргүй хүлээн авч, ДУА-ын Засаг даргын 01А/522, 01А/313 тоот захирамжаар 4,659.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 64,552.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,280,095.8 мянган төгрөг болж 109,153.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 485,553.9 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг баталсан байна.

Тайлант онд батлагдсан төсвийг 114,265.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Энэ нь Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс мөн хуримын ордны төлбөр нэмэгдсэнтэй холбоотойгоор хуримын ордны төсвийн 27,804.0 мянган төгрөг, хүүхдийн зуслангийн орлого мөн төлбөр нэмэгдсэнтэйгээр 86,461.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр үндсэн үйл ажиллагааны орлогоос 492,819.2 мянган төгрөг буюу 81.9 хувь, орон нутгийн төсвөөс 107,000.0 мянган төгрөг буюу 18.1 хувийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон төсвөөс 107,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 107,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 489,174.2 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 3,645.0 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	72207-Хүүхдийн хөгжил, хамгаалал	492,819.20	487,764.00	(5,055.20)	99.0%
1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	492,819.20	487,764.00	(5,055.20)	99.0%
2	72212-Гэр бүлийн хөгжил, хамгаалал	107,000.00	107,000.00	-	100.0%
2	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	107,000.00	107,000.00	-	100.0%
Нийт дүн		599,819.20	594,764.00	(5,055.20)	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус байгууллага нь үйлчлэх 8 ажилтантайгаар ажиллаж, 210901-Бараа үйлчилгээний бусад зардалд 157,029.6 мянган төгрөгийг зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээ шууд байгуулахаар 416,719.9 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 29,000.0 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч оролцогч ирээгүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд Дарханы Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын нэрээр 29,000.0 мянган төгрөгийн мах худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ч нэг оролцогч ороогүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зулзагын голын хүүхдийн зуслангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын бараа материалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Зулзагын голын хүүхдийн зуслангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 34 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн тайланг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 442,340.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,423.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Зулзагын голын хүүхдийн зуслангийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд бараа үйлчилгээний бусад зардлыг 3,644.9 мянган төгрөгөөр хэмнэж, оны эцэст 1,410.2 мянган төгрөгийг хэмнэж орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2. Худалдан авах ажиллагааны тухай хуулийн хэрэгжилт

Хүнсний материалтай холбоотой асуудал

5.3.1.1 Илрүүлэлт: Аудитаар тайланд махнаас бусад 89,223.4 мянган төгрөгийн хүнсний материал хувьд худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг цахимд байршуулаагүй, зохион байгуулахгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.3.-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна

5.3.1.2 Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоожмийн хэрэгжүүлж ажиллах.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх онд аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Тайлангийн 4.4.2 дахь хэсэгт дурдсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Аудитаар тайланд махнаас бусад 89,223.4 мянган төгрөгийн хүнсний материал хувьд худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг цахимд байршуулаагүй, зохион байгуулахгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.	1	89,223.4	-	-	-	-	1	89,223.4
Дүн	1	89,223.4	-	-	-	-	1	89,223.4